



АЙМГИЙН ИТХ-ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Дарга, Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Ахлах аудитор: М.Айнур
Утас: 94159291
Цахим хаяг:
ainurmarkhava@yahoo.com

Хаяг: Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар
Цахим хуудас: www.audit.mn

2018 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /БӨА-2018/2/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аймгийн ИТХ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аймгийн ИТХ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-ноос 1 дугаар сарын 29-ны хооронд хийхээр төлөвлөж, аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Аймгийн ИТХ-ын 2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 2017 оны 1 дугаар сарын 25-нд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 24-ноос 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 25-нд Аймгийн ИТХ-ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Аймгийн ИТХ-ын төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын

санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Ард иргэдээр сонгогдсон төлөөлөгчдөөр дамжуулан орон нутагт төрийн эрхийг хэрэгжүүлдэг орон нутгийн төлөөллийн байгууллага” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Аймгийн ИТХ-ын захирал нь Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Аймгийн ИТХ-ын 2017 оны төсвийг орон нутгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Аймгийн ИТХ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 15-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус цэцэрлэг нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан

бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Аймгийн ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Аймгийн ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Санхүүгийн тооцоолох төв” ХХК-ны “Аколоус” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Аймгийн ИТХ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед 24 буюу “их” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу аймгийн ТЕЗ-ийн тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын төсвийн захирагч нь 2017 онд 367,1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 358,0 сая төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 9,0 сая төгрөгийн санхүүжилт авч бүгд 367,0 сая төгрөгийн төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар үзвэл: цалингийн зардалд 81,8 сая төгрөгийг, НДШ-ийн зардалд 9,0 сая төгрөгийг, хангамж бараа материалын зардалд 31,3 сая төгрөгийг, эд хогшил худалдан авах зардалд 0,7 сая төгрөгийг, томилот зочны зардалд 5,1 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 144,1 сая төгрөгийг, бусад бараа үйлчилгээний зардалд 59,8 сая төгрөгийг, урсгал шилжүүлэгт 35,4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-ын орон тоог удирдах 2, гүйцэтгэх ажилтан 7, үйлчилэх 1 бүгд 10 орон тоогоор баталсан ба гүйцэтгэлээр 11 орон тоо ажиллуулсан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 77,4 төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулсны дотор урсгал зардалд 77,4 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: 76.4 сая төгрөгийг УИХ-ын тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран Цвещарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээс, 1,0 сая төгрөгийг УИХ-ын тамгын газраас олгосон байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төвсийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу shilendans.gov.mn вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагдсан төсвийн мэдээллийг оруулсан байна. 2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар Аймгийн ИТХ нь мэдээлэлээ бүрэн оруулсан, зөрчил дутагдал гараагүй байна.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-ман файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 2 чиглэлд 5 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Үр дагаварыг тодорхойлвол: Аудитаар санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхээр алдаа зөрчил илрээгүй болно.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Аймгийн ИТХ-ын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт орлого, нэмэлт санхүүжилт, цалин, НДШ, ХХОАТ, шатахуун, тэтгэврийн тэтгэмж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, бусад бараа үйлчилгээний зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант оны онцлог гүйлгээний талаар тодруулбал:

Тайлант онд онцлох үйл явдал болоогүй.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг алдаа зөрчил илрээгүй боловч анхаарал татах дараах асуудал байна. Үүнд:

1. Оны эцэст ХХОАТ-т 0.9 сая төгрөгийг, тээвэр шатахуунд 1.4 сая төгрөгийн өглөг үүсгэж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16.5.5, 16.5.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дах заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.*

2. Цалингаас суутгасан 411.2 мянган төгрөгийн ХХОАТ-ыг санхүүгийн тайланд авлагаар харуулаагүй үлдээж, цалингийн санг НД-ын тайланд 1864.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, 205.1 мянган төгрөгийн НДШ-ийг дутуу төлсөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: *Дутуу төлсөн татварыг нөхөн төлүүлэхээр акт тогтоож, зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.*

3. Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Н.Бейбитханд Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 18 дугаар тогтоолоор 2017 оны 03 дугаар сарын 07-ний өдөр гадаадад сургалтын зардалд олгосон 5.0 сая төгрөгийн сургалтанд хамрагдсан талаарх нотлох баримтуудыг бүрдүүлж санхүүгийн баримтанд хавсаргаагүй, албан томилолтын тайланг гаргуулж аваагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.-д "анхан шатны браимт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэнд нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: *Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.*

4. Аймгийн ИТХ-ын хурлын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан К.Баймуратын өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн мөнгийг үнэн зөв тооцож олгосон эсэхийг нотлох баримтуудыг бүрдүүлж санхүүгийн баримтанд хавсаргаагүйгээс шалгах боломжгүй, тэтгэмжийг үнэн зөв тооцож олгосон эсэх талаар хангалттай нотолгоо олж чадаагүй болно. К.Баймурат нь өөрөө улсад 40.1 жил ажилласан гэж үзэж байгаа ба ня-бо нь 33.5 жил ажилласанаар тооцсон байна. Тэтгэмжийг олгохдоо 1 сарын дундаж цалинг 853812 төгрөгөөр, 29.5 жилээр тооцож олгожээ. Энэ нь Засгийн газрын 2014 оны "төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-д нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: *Дахин хяналтаар тогтоох.*

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Аймгийн ИТХ-ын 2017 оны төсвийг Сангийн яамнаас хянасан төсвийн хязгаараас даруй 2,5 дахин нэмэгдүүлж баталсан байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Аймгийн ИТХ-ын 2017 оны төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг санхүүгийн тайлангийн аудитаар түүвэр сорилын аргаар шалгасан бөгөөд нарийвчлан шалгаж дүгнэлт гаргах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар авч үзэх шаардлагатай.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх онд зөвлөмж өгөгдөөгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН
ОГНОО:2018.02.28

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК
ОГНОО:2018.02.28

БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР

М.АЙНУР ОГНОО:2018.02.28